



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/193.

Мандалговь.

Зохион байгуулалтын арга хэмжээ  
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 115 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 46 дугаар тушаал, 18 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг диско баар, цахим тоглоом болон хүүхдийн тоглоомын газар, амралт, жуулчны газар, үзэсгэлэн худалдаа, хурим найр, олон нийтийг хамарсан уралдаан тэмцээн зохион байгуулахыг 2021 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд хориглож, бусад төрлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ажиллах цагийн хуваарийг 09.00 цагаас 21.00 цагийн хооронд байхаар тогтоож хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд 15 суманд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээр нэвтэрч байгаа коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын 2 тунд бүрэн хамрагдсанаас хойш 14 хоног болсон, сүүлийн 4 сарын хугацаанд коронавирусын халдвараар өвчилж эдгэрсэн иргэдээс бусад иргэдийн PCR шинжилгээний дүнг үндэслэн, түргэвчилсэн шинжилгээнд хамруулан гэрийн ажиглалтад 7 хоног шилжүүлэх арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хот хоорондын зорчигч тээврийн хэрэгслийн тасалбарыг цахимаар худалдаалах нөхцөлийг бүрдүүлж, цахимаар худалдаалах боломжгүй тохиолдолд

481210533

халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж, хяналт тавьж ажиллахыг Автотээврийн төв (З.Хүрэлбаатар) -д үүрэг болгосугай.

4. Коронавирусын өвчлөл бүртгэгдсэн Эрдэнэдалай сумаас 05 дугаар сарын 22-ны, Өлзийт сумаас 05 дугаар сарын 24-ний, Дэрэн сумаас 05 дугаар сарын 25-ны өдрөөс орох гарах хөдөлгөөнийг тус тус нээж хэвийн үргэлжлүүлэхийг дээрх сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Л.Доржбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



М.АНХБАЯР